

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2020 оны 03 дугаар сарын 27

Сонгон шалгаруулалт шалгаруулалтын нэр: **Адагийн ордын 2-р хүдрийн биетийн геологийн зүсэлт I - VIII хооронд бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах**

Монголросцветмет ТӨҮГ нь эрх бүхий оролцогчдоос бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авна. Сонгон шалгаруулалт нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **сүүлийн 2 жил буюу 2018 он, 2019 он.** Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь **500 сая төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **300 сая төгрөгөөс багагүй байх ба харилцагч банкнаас тодорхойлолт авах тохиолдолд уг сонгон шалгаруулалт ялсан тохиолдолд зээл олгох боломжтой байна гэсэн утга бүхий банкны тодорхойлолтыг шаардлага хангасан материал гэж үзнэ.**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил: **сүүлийн 2 жил буюу 2018 он, 2019 он**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **тийм, ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Геологийн эрэл хайгуулын болон Уул уурхайн чиглэлээр олборлолтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий тэмдэглэлтэй байх**

Саналыг 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан сонгон шалгаруулалтыг 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг 40 минутад нээнэ.

Гадаадын этгээд санал ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд сонгон шалгаруулалтын баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот 51, ш/х – 002
Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө. 22-р хороо,
“Монголросцветмет” ТӨҮГ-ийн байр, 504 тоот өрөө,
И-мейл: mailbox@monros.mn.
Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-158,